

НИЙСЛЭЛИЙН СПОРТЫН ХОРООНЫ СПОРТЫН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН
2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. “БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ- ҮР ДҮН”:

**б/ Биеийн тамир, спортыг хөгжлүүлэх талаар төрөөс баримтлах бодлого
Хэрэгжилт-75%**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийслэлд болон 5 дүүрэгт баригдаж байгаа спорт цогцолборуудын барилгын ажлын гүйцэтгэл 75 хувьтай байна. Үүнээс Нийслэлийн спорт цогцолбор-30%, Баянгол дүүргийн спорт цогцолбор-95%, Баянзүрх дүүргийн спорт цогцолбор-90%, Чингэлтэй дүүргийн спорт цогцолбор-98%, Налайх дүүргийн спорт цогцолбор-95%, Сүхбаатар дүүргийн спорт цогцолбор-40%

**в/ Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр –
хэрэгжилт 96,6%**

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд биеийн тамир, спортын чиглэлээр тусгагдсан 2 зорилт, 3 арга хэмжээний биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж, хяналт – шинжилгээ, үнэлгээний дүн 100%.

Байгууллагын даргын дэргэдэх удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт – шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн.

Энэхүү хөтөлбөрийн 2020 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор журмын дагуу үнэлэхэд үр дүнтэй–зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гаргасан учир 100 хувьтай хэрэгжүүлсэн гэж үзлээ.

**3.2.54-4. Үндэсний шигшээ багийн /өсвөр, оюутан, залуучууд, насанд хүрэгчид/
үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтад оруулж, сургалт-дасгалжуулалтын
уялдааг хангах. Хэрэгжилт 100%**

Биеийн тамир, спортын тухай хуулийн 18.5 дахь заалт, Нийслэлийн засаг даргын 2015 оны А/118 дугаар захирамжийн дагуу өсвөрийн шигшээ багийг нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын дэргэд байгуулан үйл ажиллагааг дэмжин орон нутгийн төсвөөр санхүүжүүлэн ажиллалаа Өсвөрийн шигшээ багууд 2020 онд спортын 22 төрлөөр 82 дасгалжуулагч 2695 тамирчинтай, сургалт дасгалжуулалтаа явуулж, өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэж ажиллалаа.




Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Шинэ корона вирусын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108 дугаар захирамжаар олон нийтийг хамарсан спортын тэмцээн, уралдаан зохион байгуулахыг хориглосон тул Нийслэлийн Спортын хорооноос өгсөн үүрэг, чиглэлийн дагуу 2020 оны 02 дугаар сарын 01-ээс 09 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл өсвөрийн шигшээ багуудын багш, дасгалжуулагч нар хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу цахим зайн сургалтыг 480 удаа явуулж тамирчдын бэлтгэлжилтийг хангаж ажилласан.

Засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 103 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн “Эдийн засгийн өсөлтийг дэмжих зарим арга хэмжээний тухай” А/1114 дүгээр захирамжаар нийтийг хамарсан, олон нийтийн арга хэмжээг нээсэн тул 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдөр хүртэл өсвөрийн шигшээ багийн тамирчид, дасгалжуулагч нар “COVID-19” шинэ төрлийн корона вирусын халдвараас сэргийлж, Нийслэлийн Засаг даргын захирамж, Улсын Онцгой байдлын комиссын гаргасан тогтоол, шийдвэрийг дагаж мөрдөн, ариутгал халдваргүйжүүлэлт хийж, халууны хэмжилтийг тогтмол үзэж тодорхой тооны тамирчидтай заал, талбайд бэлтгэл, сургуулилтаа үргэлжлүүлэн хэвийн горимд шилжүүлэн ажилласан.

2020 онд хот, улсын аварга шалгаруулах тэмцээн болон олон улс, тив, дэлхийн тэмцээнүүдээс нийт 139 алт, 96 мөнгө, 103 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүлээ. Өсвөрийн шигшээ багт орон нутгийн төсвөөс 2020 онд нийт 122.878.800 төгрөг зарцуулсан байна.

“COVID-19” шинэ төрлийн корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан Улсын онцгой комиссын 2020 оны 12 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1241 дүгээр захирамжаар спортын үйл ажиллагаануудыг хориглосон тул Нийслэлийн Спортын хорооноос өгсөн үүрэг, чиглэлийн дагуу 2020 оны 11 дүгээр сарын 11-ээс 12 дугаар сарын 30-ны өдөр хүртэл өсвөрийн шигшээ багуудын багш, дасгалжуулагч нар хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу 493 удаа цахим зайн сургалт явуулж тамирчдын бэлтгэлжилтийг ханган ажилласан.



3.2.54-5. Спортын салбарын мэдээллийн технологийн сан байгуулах

Биеийн тамир, спортын улсын анхдугаар үзлэг, тооллогыг нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулж нэгдсэн судалгааг гаргасан. Энэхүү судалгаанаас гарсан дүн мэдээг “Захиргааны статистик мэдээ, тайлан боловсруулах онлайн программ”-д бүрэн оруулсан.

Биеийн тамир, спортын салбарын цахим мэдээллийн нэгдсэн сан 2021 онд ажиллаж эхлэхтэй холбогдуулан мэдээлэл бэлтгэж оруулах талаарх үе шаттай сургалтуудад аймаг, нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын хороод, спортын холбоодын холбогдох мэргэжилтнүүд хамрагдсан.

Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа спортын барилга байгууламжийн хүртээмжийг нийслэлийн хүн амд харьцуулсан 2018 оны судалгаагаар спортын барилга байгууламжийн хүртээмж 1000 хүн тутамд биеийн тамирын 60 м² талбай оногдож байсан бол 2020 онд хийсэн судалгаагаар 1000 хүн тутамд 62 м² болж 2 м²-аар нэмэгдүүлсэн байна.

Спортын барилга байгууламжийн хүртээмжийг жилээс жилд нэмэгдүүлэх чиглэлээр Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тус тус тусгуулсан.


г/ Улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл – хэрэгжилт 75%

4.4.9 Нийслэлд болон Сүхбаатар, Баянзүрх, Налайх, Баянгол, Чингэлтэй дүүрэгт спортын 6 цогцолбор барих ажлыг үе шаттай хэрэгжүүлж, өвөл, зуны спортын төрлийн биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн цогцолбор барьж байгуулах ажлыг дэмжиж ажиллана гэсэн заалтын дагуу.

2010-2020 оны хооронд Нийслэлд шинээр баригдаж байгаа спорт цогцолборуудын ажлын биелэлтийг улирал бүр гарган байгууллагын удирдлага болон дээд шатны байгууллагуудыг мэдээллээр хангаж ажиллалаа. /Хэрэгжилт 75%/

Чингэлтэй дүүргийн спорт цогцолбор

Чингэлтэй дүүргийн спорт цогцолборын нийт өртөг 14164.3 сая төгрөг бөгөөд гүйцэтгэгч байгууллага “Люкс-вүүд” ХХК ажлын 98%-ийг гүйцэтгээд байна. БТСХ-ны спорт цогцолбор 2020 оны 06 дугаар сард А, В влок ашиглалтад орж С влокын ажлын дотоод засал, тоноглол дутуу байна.





Баянзүрх дүүргийн спорт цогцолбор:
Спорт цогцолборын нийт өртөг 8229.3 сая төгрөг
-Нийт авсан санхүүжилт 8039.3 сая төгрөг
-2020 оны улсын төсөвт төсөв тусгаадаагүй. /царцсан/
-Нийт ажлын гүйцэтгэл 90%
-Үлдэгдэл санхүүжилт 190.0 сая төгрөг
-Нэмэлт санхүүжилт: 1274.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт шаардлагатай.

Баянгол дүүргийн спорт цогцолбор:
Баянгол дүүргийн спорт цогцолборын нийт өртөг 9005,4 сая төгрөг бөгөөд урд жилүүдэд 5002.0 сая төгрөгийн санхүүжилтээр барилгын ажлыг гүйцэтгэсэн. 2020 онд 2.2 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдаж БСШУСЯ-тай гэрээ байгуулан “Молор Констракшн” ХХК нь тус барилгын ажлын 95%-ийг гүйцэтгээд байна.



Налайх дүүргийн спорт цогцолбор:
Налайх дүүргийн спорт цогцолборын нийт өртөг 10397.9 сая төгрөгөөр “БҮРД констракшн” ХХК нь нийт ажлын 95%-ийг хийж гүйцэтгээд байна. 2020 оны төсөвт дулааны шугам холбох шаардлагатай нэмэлт санхүүжилт суугдаагүй байна.



Сүхбаатар дүүргийн спорт цогцолбор:
Сүхбаатар дүүргийн спорт цогцолборын нийт өртөг 7377.4 сая төгрөг бөгөөд урд онуудад 2800.0 сая төгрөгөөр барилгын ажлын 30%-ийг хийж гүйцэтгүүлсэн. 2020 оны төсөвт 4,2 тэрбум төгрөгийн санхүүжилт улсын тусгагдсан боловч тус санхүүжилт нь дүүргийн төсөвт ороогүй байна. “Грейн ресурс” ХХК нь барилгын ажлыг эхлүүлж 40%-ийн гүйцэтгэлтэй болгоод байна.



Нийслэлийн спорт хорооны цогцолбор:

- Спорт цогцолборын нийт өртөг 7280.2 сая төгрөг
- Нийт авсан санхүүжилт 3257.0 сая төгрөг
- Нийт ажлын гүйцэтгэл 30%
- Үлдэгдэл санхүүжилт 4023.2 сая төгрөг
- 2020 онд 4023.2 сая төгрөгийг шийдвэрлүүлэх шаардлагатай байсан боловч улсын төсөвт санхүүжилт суугдаагүй байна.

з, к, л. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4-80-4-99, нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 4.4.1-4.4.9-д тусгагдсан заалтууд - Хэрэгжилт 94,7%

4.4.1. Олон Улсын жишигт нийцсэн шинэ цэнгэлдэх хүрээлэн барина. Үнэлэх боломжгүй

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 315 дугаар тогтоолын дагуу Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газраас Улаанбаатар хотод олон улсын жишигт нийцсэн үндэсний хэв шинж бүхий 30-40 мянган хүний багтаамжтай “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэнг нийслэлийн Хан-Уул дүүргийн 08 дугаар хорооны нутаг дэвсгэрт Нисэх, Яармагийн аюулгүйн тойргийн зүүн урд хэсэгт барьж байгуулахаар шийдвэрлэсэн.

“Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн”-гийн төслийн техник, эдийн засгийн үндэслэл, эх загвар зураг (эскиз)-ийг боловсруулах ажлыг Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, хот байгуулалт хөгжлийн газар хамтран гүйцэтгэж байна. “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн” байгуулах төслийн концепц, загвар зураг төсөл боловсруулах уралдааныг зарлан, сонгон шалгаруулалтыг хийж “Хаус дизайн” ХХК-ны боловсруулсан “Хийморь цогцолбор” бүтээл шалгарсан. Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1046 дугаар “Газар эзэмших эрх олгох тухай” захирамжаар Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт байршуулан 30.0 га газарт “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн” байгуулах зориулалтаар 15 жилийн хугацаатай газар эзэмших эрхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт олгосон боловч барилгын ажил хийгдэж эхлээгүй байна.

4.4.2. Нийслэлийн иргэдэд нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээг хүргэх тогтолцоог боловсронгуй болгож, Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ. Хэрэгжилт 93%

1. 2020 онд “Азийн хүүхдүүд” олон улсын спортын наадам байгуулахаар шийдвэрлэсэн боловч дэлхий нийтэд тархаад байгаа “Covid-19” цар тахал буюу коронавирусаас урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Шинэ коронавирустой эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108, “Коронавируст /Ковид-19/ цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” А/1241 дүгээр захирамжуудаар олон нийтийг хамарсан спортын арга хэмжээ зохион байгуулахыг хориглосон тул зохион байгуулагдаагүй болно.

2020 оны “Азийн хүүхдүүд” олон улсын спортын наадам, 2023 оны “Зүүн Азийн залуучуудын II наадам”-ын бэлтгэл ажлын хүрээнд Хан-Уул дүүргийн 8-р хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй өвлийн спортын битүү дээвэртэй ордон, усан бассейн, хөлбөмбөгийн талбай зэрэг томоохон бүтээн байгуулалтын ажлууд явагдаж байна.

Тус өвлийн спортын битүү дээвэртэй ордон нь хоккей, тэшүүр, шорт-трек, уран гулгалт, кёрлинг зэрэг өвлийн олимпийн төрлөөр хичээллэх боломжтой 7800 м² ашигтай талбайтай 110х80 метр хэмжээтэй 2500 хүний суудалтай байх бөгөөд Степп Арена ХХК ажлын гүйцэтгэлийг 85%-тай хэрэгжүүлж байна.

Олон улсын стандартад нийцсэн 50 м урт, 1.5 м гүн, 10 эгнээ замтай усан бассейн барих барилгын ажлыг гүйцэтгэгч байгууллагаар “Абсолют авто трейд” ХХК шалгарч ажлын гүйцэтгэл 85%-тай хэрэгжүүлж байна.

Монголын хөлбөмбөгийн холбоонд дэлхийн хөлбөмбөгийн холбоо (FIFA)-оос олгогдсон хөрөнгө оруулалтын хүрээнд хийгдэх 109х74м хэмжээтэй хөлбөмбөгийн талбай нь бүрэн усалгааны системээр тоноглогдсон, 300 LUX хүчин чадалтай 4 гэрэлтүүлэгч бүхий талбайн бүтээн байгуулалтийн ажлын гүйцэтгэл 90%-тай хийгдэж байна.

2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.2. Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 4-82 дахь заалтын дагуу Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 88 дугаар тогтоолоор 4 зорилт, тэдгээрийн хүрээнд хэрэгжүүлэх нийт 19 үйл ажиллагаа бүхий “Нийслэлд биеийн тамир, спортыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг батлуулсан.

Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хагас бүтэн жилээр тайлагнаж, 2020 онд Биеийн тамир, спортын арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 190.100.000 төгрөг баталж өгсөнөөс 54.962.300 төгрөг, “Зүйн хойд Азийн бизнес, аялал жуулчлал, соёл, санхүүгийн арга хэмжээний зардал”-аас 162.580.000 төгрөг баталж өгсөнөөс 43.800.000 төгрөг, Улсын төсвөөс төсвийн хөрөнгө оруулалтаар 2.4 тэрбум төгрөг зарцуулсан.

Нийт 2.500.200.000 /хоёр тэрбум таван зуун сая хоёр зуун мянган/ төгрөг зарцуулсан бөгөөд хэрэгжилтийн явц 93% байна.

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор журмын дагуу үнэлэхэд үр дүнтэй-зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гаргасан учир 100 хувьтай хэрэгжүүлсэн гэж дүгнэснийг байгууллагын даргын дэргэдэх удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн баталгаажуулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хугацаанд нь хүргүүлж ажиллаа.

4.4.7. Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Улаанбаатар лиг” сагсан бөмбөг, волейбол, “Дуулиан-2020” хөл бөмбөг, “Ub Cup” хөл бөмбөг, 3х3 сагсан бөмбөгийн тэмцээнүүдийг зохион байгуулна. Хэрэгжилт 100%

1. Нийслэлийн Засаг даргын нэрэмжит 2019-2020 оны хичээлийн жилийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Улаанбаатар лиг” сагсан бөмбөгийн тэмцээнийг бага, дунд, ахлах насны ангиллаар 3 үе шаттайгаар 11 дэх жилдээ зохион байгуулж, анхан шатны тэмцээнүүдэд нийслэлийн 9 дүүргийн Ерөнхий боловсролын 121 сургуулийн охид, хөвгүүдийн 6413 багийн 85000 гаруй сурагчидыг хамруулсан.



Нийслэлийн шигшээ тэмцээнийг 2020 оны 10 дугаар сарын 17-20-ны өдрүүдэд “Буянт Ухаа” спортын ордонд зохион байгуулж, охид хөвгүүдийн 96 багийн 1248 сурагч, давхардсан тоогоор 6509 багийн 86240 сурагч хамруулж, Зүүн хойд Азийн бизнес, аялал жуулчлал, соёл, санхүүгийн төв болгох зардлаас 31.000.000 төгрөг зарцуулсан.



Анхан шатны тэмцээнийг амжилттай сайн зохион байгуулсан сургуулиар Б.Болортуяа захиралтай Чингэлтэй дүүргийн 117 дугаар сургууль шалгарч “Шилдгийн шилдэг сургууль” өргөмжлөл, “Нэг сая төгрөгийн батламж”-ийг гардан авсан.

2. Нийслэлийн Засаг даргын нэрэмжит ЕБС-ийн 2019-2020 оны хичээлийн жилийн “Улаанбаатар лиг” волейболын тэмцээнийг дунд нас, ахлах нас гэсэн 2 ангиллаар 3 шаттай зохион байгуулсан. Анхан шатны тэмцээнийг 2019 оны 09-12 дугаар сарын 30 хүртэл зохион байгуулан нийслэлийн 9 дүүргийн 64 сургуулийн 30.800 сурагч хамруулсан.

Нийслэлийн шигшээ тэмцээнийг 2020 оны 11 дүгээр сарын 09-10-ны өдрүүдэд зохион байгуулж, 44 сургуулийн 832 сурагч, давхардсан тоогоор 110 сургуулийн 31632 сурагч хамруулж, нийслэлийн төсвөөс 16.392.000 төгрөг зарцуулсан.

2019-2020 оны хичээлийн жилийн “Шилдэгийн шилдэг сургууль”-иар 3.Тунгалаг захиралтай Чингэлтэй дүүргийн 37 дугаар сургууль шалгарч батламж гардан авсан.



3. “Дуулиан-2020” хөлбөмбөгийн тэмцээнийг нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд охид, хөвгүүд тус бүр 4 нас /6-11, 13, 15, 17 хүртэлх/-ны ангилалаар 3 үе шаттай зохион байгуулсан. Анхан шатны тэмцээнийг 2019 оны есдүгээр сараас 2020 оны нэгдүгээр сарын хооронд явуулж нийт 87 сургуулийн 30.000 сурагч хамруулсан. Нийслэлийн шигшээ тэмцээнийг 2020 оны 12 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөсөн боловч Улсын онцгой комиссын 2020 оны 34 дүгээр хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Коронавируст /Ковид-19/ цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” А/1241, Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай А/1242, Гамшгаас хамгаалах Бүх нийтийн бэлэн байдлын зэргийг бууруулсантай холбогдуулан хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай А/1280 дугаар захирамжуудаар

олон нийтийг хамарсан спортын арга хэмжээг зохион байгуулахыг хориглосон тул арга хэмжээг явуулах боломжгүй болсон.

4. “Ub Cup” хөл бөмбөг, Хүүхэд залуучуудын дунд 3x3 сагсан бөмбөгийн нээлттэй тэмцээнүүдийг II улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн боловч Дэлхий нийтэд тархаад байгаа “Covid-19” цар тахал буюу коронавирусаас урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Шинэ коронавирuсын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108 дугаар захирамжийн дагуу хойшлогдсон.

Засгийн газрын 2020 оны 103 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1114 дүгээр захирамжаар нийтийг хамарсан олон нийтийн арга хэмжээг нээсэн тул тус тэмцээнийг 2020 оны 11 дүгээр сарын 15-25-ны өдрүүдэд зохион байгуулахаар заавар удирдамжаа гарган бэлтгэл ажлаа хангаад байсан боловч дахин “Covid-19” цар тахал дэгдсэнтэй холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1241 дугаар захирамжаар нийтийг хамарсан уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглосон тул тэмцээн зохион байгуулах боломжгүй болсон.

4.4.8. Өсвөр үе, хүүхэд залуучуудыг бие бялдрыг чийрэгжүүлэх авьяас, ур чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааг багийн спортоор дамжуулан хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, үндэсний болон өвөл зуны спортын төрлөөр 30-аас доошгүй уралдаан тэмцээн зохион байгуулна. Хэрэгжилт 100%

1. Спортын холбоодтой хамтран ажиллах гэрээ байгуулж хамтран ажиллах ажлын хүрээнд:

Нийслэлийн Спортын хороо нь 2020 онд биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 16 спортын холбоо (Монголын Волейболын холбоо, Монголын Гимнастикийн холбоо, Монголын Хэт холын марафон гүйлтийн холбоо, Монголын Софт теннисний холбоо, Монголын Тэшүүрийн холбоо, Монголын Дугуйн холбоо, Монголын Байт харвааны холбоо, Монголын Жүдо бөхийн холбоо, Монголын Ширээний теннис, Монголын бадминтон, Монголын Хөл бөмбөгийн холбоо, Монголын парабочи холбоо, Монголын шатрын холбоо, Монголын хонхтой бөмбөгийн холбоо, Монголын Бүжгийн спортын холбоо, Монголын Сагсан бөмбөгийн холбоо)-той Улаанбаатар хотын 2020 оны аварга шалгаруулах тэмцээнүүдийг зохион байгуулах, уралдаан тэмцээн, нийтийн биеийн тамирын аливаа арга хэмжээнд мэргэжлийн удирдлагаар ханган хамтарч ажиллахаар гэрээ байгуулан ажилласан.


Монголын Оюутны спортын V наадмын нийслэлийн бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг /сагсан бөмбөг, волейбол, сагсан бөмбөгийн 3:3/ багийн спортын төрлөөр Монголын Волейболын холбоо, Монголын Сагсан бөмбөгийн холбоотой хамтран 2020 оны 05 дугаар сард зохион байгуулхаар төлөвлөсөн боловч Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108 дугаар захирамжаар олон нийтийг хамарсан спортын уралдаан тэмцээн, арга хэмжээ зохион байгуулахыг тодорхойгүй хугацаагаар хориглосон тул бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулалгүйгээр улсын шатанд оролцуулах шийдвэрийг Улсын Биеийн тамир, спортын хорооноос гаргасан.

2. Засгийн газрын 2020 оны 103 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1114 дүгээр захирамжаар нийтийг хамарсан олон нийтийн арга хэмжээг нээсэн хугацаанд Спортын уралдаан тэмцээнийг 11 төрлөөр зохион байгуулж, 247 багийн 3496 тамирчин хамруулж, нийслэлийн төсвөөс 54.008.000 төгрөг, Зүүн хойд Азийн бизнес, аялал жуулчлал, соёл, санхүүгийн төв болгох зардлаас 31.000.000 төгрөг нийт 85.008.000 төгрөг зарцуулсан.

- Улаанбаатар хотын аварга шалгаруулах гүйлтийн тэшүүрийн тэмцээн:

Тэшүүрийн спортыг олон нийтэд сурталчлах бүх нийтийн хүртээл болгох, өсвөрийн тамирчдын техник, ур чадвар, тактикийг сайжруулах зорилгоор “Тэшүүрийн тэмцээн”-ийг 2020 оны 02 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд Хандгайтын 400м стандартын мөсөн

гулгуурын талбайд зохион байгуулж 9 байгууллагын 69 тамирчин хамтрагдаж нийслэлийн төсвөөс 2.602.000 төгрөг зарцуулсан.



- Улаанбаатар хотын аварга шалгаруулах байт харвааны тэмцээн

Улаанбаатар хотын 2020 оны аварга шалгаруулах байт харвааны тэмцээнийг 09 дүгээр сарын 18-20-ны өдрүүдэд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд рекурвын болон кампаундын төрлөөр зохион байгуулж, 7 багийн 60 гаруй тамирчин хамруулж, нийслэлийн төсвөөс 3.450.000 төгрөг зарцуулсан.



- Улаанбаатар хотын аварга шалгаруулах дугуйн тэмцээн

Улаанбаатар хотын 2020 оны аварга шалгаруулах дугуйн тэмцээнийг 09 дүгээр сарын 19-20-ны өдрүүдэд Төв аймгийн Алтан булаг суманд 5 насны ангиллалаар зохион байгуулж, 11 багийн 110 гаруй тамирчин хамруулж, нийслэлийн төсвөөс 2.662.000 төгрөг зарцуулсан.



- Улаанбаатар хотын аварга шалгаруулах софт теннисний тэмцээн

Улаанбаатар хотын 2020 оны аварга шалгаруулах софт теннисний тэмцээнийг 10-р сарын 11-13-ны өдрүүдэд Хан-Уул дүүргийн Биеийн тамир, спортын хорооны спорт зааланд 5 насны ангилал, 2 төрлөөр зохион байгуулж, 16 байгууллагуудын 100 гаруй өсвөрийн тамирчин хамруулж, нийслэлийн төсвөөс 3.972.000 төгрөг зарцуулсан.



- Улаанбаатар хотын аварга шалгаруулах аэробик гимнастикийн тэмцээн

Улаанбаатар хотын 2020 оны аварга шалгаруулах Аэробик гимнастикийн тэмцээнийг 10-р сарын 24-25-ны өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хорооны спорт цогцолборт зохион байгуулж, 14 байгууллагын 185 тамирчин хамруулж, нийслэлийн төсвөөс 9.424.000 төгрөг зарцуулсан.



- Улаанбаатар хотын аварга шалгаруулах спортын гимнастикийн тэмцээн

Улаанбаатар хотын 2020 оны аварга шалгаруулах спортын гимнастикийн тэмцээнийг 11 дүгээр сарын 07-08-ны өдрүүдэд Монголын гимнастикийн холбооны гимнастикийн төв зааланд эрэгтэй эмэгтэй төрөлд, нийт 10 хэрэглэл, 20 зэргийн ангилалаар зохион байгуулж, 13 байгууллын 100 гаруй тамирчин хамруулж, нийслэлийн төсвөөс 7.442.000 төгрөг зарцуулсан.



- Улаанбаатар хотын аварга шалгаруулах Уран сайхны гимнастикийн тэмцээн

Улаанбаатар хотын 2020 оны аварга шалгаруулах Уран сайхны гимнастикийн тэмцээнийг 10 дугаар сарын 31-ээс 11 дүгээр сарын 01-ний өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хорооны спорт зааланд ганцаарчилсан төрөлд 19 насны

ангилалаар, багийн төрөлд 4 хэрэглэлээр зохион байгуулж, 11 байгууллагын 184 тамирчин хамруулж, нийслэлийн төсвөөс 6.616.000 төгрөг зарцуулсан.



- Улаанбаатар хотын аварга шалгаруулах ширээний теннисний тэмцээн

Улаанбаатар хотын 2020 оны аварга шалгаруулах ширээний теннисний тэмцээнийг 10 дугаар сарын 30-аас 11 дүгээр сарын 08-ны өдрүүдэд “Нийслэл”, “Оч” клубүүдэд өсвөр үе, залуучууд, ахмад гэсэн 3 насны ангилалаар зохион байгуулж, 8 дүүргийн 18 байгууллагын 620 гаруй тамирчин хамруулж, нийслэлийн төсвөөс 4.282.000 төгрөг зарцуулсан.



3. 2020 онд шинээр Чингэлтэй дүүргийн биеийн тамир, спортын хорооны спортын цогцолбор ашиглалтад орж, орон нутгийн төсвийн хөрөнгөөс 151.8 сая төгрөгийн санхүүжилт авч, тоног төхөөрөмж, хэрэглэл материалаар 100%-иар хангагдсан байна.

4. Чингэлтэй дүүргийн биеийн тамир, спортын цогцолбор ашиглалтад орж орон нутгийн төсвийн 188.6 сая төгрөгний санхүүжилт авч албан өрөөний хэрэглэл, эд хогшил болон техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр 100%, Багануур дүүрэг 5 сая төгрөгний техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжийг орон нутгийн төсвийн хөрөнгөөс, Хан-Уул дүүрэг 4 ширхэг суурин компьютерыг 7.869.490 төгрөгийг үндсэн хөрөнгөөр худалдан авсан байна. Орон нутгийн төсвөөс 191.4 сая төгрөг зарцуулсан.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. “ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН” 100%

а. Дээд шатны байгууллагын тогтоол шийдвэрийн 2020 оны жилийн эцсийн байдлаар хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн баримт бичгийн 5 төрлийн /Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар/ 42 заалтын биелэлт 100%-тай хэрэгжсэн бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 100 хувьтай буюу бүрэн хэрэгжсэн гэж үнэллээ.

Үүнд:

1. Биеийн тамир, спортын тухай хууль – 1-100%
2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг - 2 – 100%
3. Засгийн газрын тогтоол - 14 – 100%

4. Засгийн газрын албан даалгавар - 1 – 100%
5. НИТХ-н тэргүүлэгчдийн тогтоол - 1 – 100%-тай хэрэгжүүлээ.

Мөн Нийслэлийн Засаг даргын захирамж-17, Нийслэлийн Онцгой комиссын хурлын тэмдэглэл-3, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл-3 тус тус www.monitoring.ub.gov.mn программд улирал тутам биелэлтийг оруулж ажилласан бөгөөд жилийн эцсийн байдлаар 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдөр шивж оруулсан.

Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөний биелэлтийг шуурхайн өмнөх долоо хоногийн Пүрэв гаригт программд оруулж байгаа бөгөөд 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 11 удаагийн үүрэг даалгаврын биелэлтийг оруулсан. Хэрэгжилт 100%

Биеийн тамир, спортын талаарх эрх зүйн актуудын мэдээсайтад тухай бүр нь оруулж ажилласан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 оны 63 дугаар зарлигийн дагуу Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэхь заалтын дагуу 2020 оны 05, 10 дугаар сарын 2 дахь 7 хоногийн хагас бүтэн сайн өдрүүдэд тохиож, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан иргэдийн бөөгнөрөл үүсгэхийг хориглосон тул тогтоосон дэглэмийг зөрчилгүй албан хаагчид өөрийн эзэмшил газарт болон хашаандаа мод тарьж, арчилгаа усалгааг хийж ажиллаа.

Биеийн тамир, спортын талаарх эрх зүйн актуудын мэдээллийг сайтад тухай бүр нь оруулж ажилласан.

б. Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/01 дүгээр захирамжийн дагуу 2020 оныг “Нэг хот – Нэг стандарт” жил болгон зарласантай холбогдуулан захирамж, төлөвлөгөө, өөрийн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг байгууллагын www.sport.ub.gov.mn сайтад тухай бүр нь байршуулж олон нийтэд сурталчилан ажилласан.

"Нэг хот-Нэг стандарт" зорилтот жилийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 3 зорилт 17 үйл ажиллагааг тусган хэрэгжүүлсэн.

Хэрэгжилтийг биелэлтийг улирал бүр гаргаж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн бөгөөд жилийн эцсийн байдлаар 95%-тай хэрэгжсэн байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. “БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН”: /Хэрэгжилт-100%/

а/ байгууллагын дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл.

-Нийслэлийн спортын хороо /2017-2020/-ны үйл ажиллагааны дунд хугацааны стратеги төлөвлөгөө, “Биеийн тамир, спортын тухай хууль”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, МУ-д биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого, цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, “Халдварт бус өвчинтэй тэмцэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, “Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 05 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Байгууллагын ил тод байдлыг хангах, шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Зорилтот жилийн хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө болон гадаад арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.

- Биеийн тамир, спортын төрийн байгууллагын үйл ажиллагааны 2019 оны мэдээг Үндэсний Статистикийн газрын маягтын дагуу 2020 оны 02 дугаар сарын 05-ны дотор хугацаанд нь нэгтгэн гаргаж Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газар, Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүллээ. Мөн дүүргийн Биеийн тамир, спортын хороодтой хамтран тус мэдээний үзүүлэлтүүдийг Биеийн тамир Спортын газрын Захиргааны статистик мэдээ, тайлан боловсруулах онлайн программд дүүрэг тус бүрээр бүрэн орууллаа.

- Шинээр боловсруулж байгаа “UCS1403B:2020 Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлт, тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага”, “UCS1102B:2020 Ерөнхий боловсролын сургуулийн гадна орчинд тавигдах ерөнхий шаардлага”, “UCS1203B:2020 Амралтын газар, жуулчны баазын гадна болон дотоод орчны тохижилт, зохион байгуулалтад тавигдах

шаардлага” стандартын баримт бичигүүдэд спортын салбарын байгууллагуудын саналыг авч нэгтгэн Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газарт хүргүүлж тус стандартын баримт бичигүүдэд тусгуулж ажиллаа.



2020 онд Стандартын техникийн хороо 2 удаа хуралдахаар төлөвлөсөн боловч Covid-19” цар тахал буюу коронавирусаас урьдчилан сэргийлэх Улсын онцгой комиссын 2020 оны 12 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 2020 оны А/108, А/1241, А/1242 дугаар захирамжаар спортын үйл ажиллагааг хориглосон тул зохион байгуулагдаагүй.

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭРХ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ:

б/ Хүний нөөц Хэрэгжилт 100%

2020 онд Дарга-1, хэлтсийн дарга-2, төрийн захиргааны албан хаагч-6, төрийн үйлчилгээний албан хаагч-1 гээд 10 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явууллаа.

Тус тогтоолын дагуу байгууллагын даргын 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар төрийн захиргааны 13 албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг баталж шинээр үүссэн 4 сул орон тоог нөхөн бүрдүүлэх зорилгоор нийтэд нээлттэй зарлаад байна.

Спортын барилга байгууламж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалыг түр орлон гүйцэтгэж байсан Б.Оюунтуяа төрийн албаны тусгай шалгалт өгч тэнцсэн тул тус албан тушаалд Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлийн 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 41 дүгээр тогтоолыг үндэслэн байгууллагын даргын 2020 оны Б/22 дугаар тушаалаар томилон ажиллуулсан.

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах үүрэг бүхий удирдах албан тушаалтнуудын мэдүүлгийг 2020 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө буюу хуулийн хугацаанд гаргуулан баталгаажуулсан.

Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг 2020 онд хэрэгжүүлэх ажлын 2 зорилт бүхий 5 үйл ажиллагааны төлөвлөгөөг 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдөр байгууллагын даргаар батлуулж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гаргаж Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсэн. Хэрэгжилт 94 хувь.

Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой А тушаал 44, Б тушаал 27 гарснаас цалингаас бусад 5.000.000 дээш үнийн дүнтэй гүйлгээг www.shilendans.gov.mn сайтад тухай бүр байршуулан ажилласан.

Байгууллагын дэргэд орон тооны бус ББНШК, Өмч хамгаалах байнгын зөвлөл, Ёс зүйн хороо нь жилийн эцсийн байдлаар тус тус 2 удаа хуралдаж үйл ажиллагаа нь тогтмолжсон байна.

Даргын дэргэдэх Удирдлагын зөвлөл нь хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон байгууллагын үйл ажиллагааны талаар нийт 17 удаа хуралдсан.

Ёс зүйн хороог 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулж, байгууллагын үйл ажиллагаанд ёс зүйн хэм хэмжээг хэвшүүлэн ажиллаж байна.

Биеийн тамир, спортын холбогдолтой статистик, судалгааны дүн мэдээг нэгтгэн 2020 оны 01 дүгээр 05-нд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Биеийн тамир, спортын газар, Нийслэлийн Статистикийн газарт тус тус хүргүүлж ажилласан.

Биеийн тамирын хөгжлийн хэлтсийн “ААНБ дахь биеийн тамир чийрэгжүүлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн”, “Оюутан залуучууд-тусгай мэргэжлийн болон их, дээд сургууль дахь биеийн тамирын асуудал хариуцсан мэргэжилтэн”, “Ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, гэр бүл, орон нутгийн нэгж, дүүрэг, хороо, хэсэг дэх биеийн тамирын асуудал хариуцсан мэргэжилтэн”, “Тогтоол шийдвэр, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн”, Спортын хөгжлийн хэлтсийн “Мэдээлэл технологи, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн” эдгээр албан тушаалыг Э.Мөнх-Эрдэнэ, Г.Бямбасайхан, Б.Солонго, Н.Өлзийжаргал, Б.Оюунтуяа нарт түр орлон гүйцэтгүүлсний 40 хувийн нэмэгдэл цалинг тус тус олгож ажилласан.

Байгууллагын даргын 2020 оны “Албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоох тухай” А/12 дугаар тушаалаар 5 албан хаагчийн цалингийн шатлалыг ахиуллаа.

Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр үнэлж нэгдүгээр улиралд 7, хоёрдугаар улиралд 7, гуравдугаар улиралд 7, дөрөвдүгээр улиралд 9 албан хаагчид хангалттай үнэлэгдсэн бөгөөд тус албан хаагч тус бүрт үндсэн цалингийн 40%-аар урамшуулал цалин нийт 9.848.938 /есөн сая найман зуун дөчин найман мянга есөн зуун гучин найм/ төгрөгийг олгосон байна.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/342, А/747 дугаар захирамжийн дагуу 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийг хүртэл Сонгинохайрхан дүүргийн 27 дугаар хорооны айл өрхөд Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах, сайжруулсан түлшний зөв хэрэглээг нэвтрүүлэх, заавар зөвлөмж хүргэх, 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 05-ныг дуустал дэлхий нийтийг хамарсан шинэ төрлийн Коронавирус /COVID-19/ гарч халдвараас иргэд, олон нийтийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд онцгой дэглэм тогтоосонтой холбогдуулан Баянгол дүүргийн 11, 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт болзошгүй эрсдэлээс сэрэмжлүүлэх, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг тогтмол хийлгэх, иргэдийн хөл хөдөлгөөнийг хязгаарлахад хяналт тавих үйл ажиллагаанд байгууллагын бүх албан хаагчид хуваарийн дагуу эргүүл хяналтыг үр дүнтэй зохион байгуулж гүйцэтгэсэн тул албан хаагч бүрт нэг сарын үндсэн цалинтай тэнцэх урамшууллыг байгууллагын даргын 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/09 дугаар тушаалаар 5.703.362 төгрөг, 2020 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн А/16 дугаар тушаалаар 6.620.490 төгрөг, нийтдээ 12.323.852 төгрөгийг урамшуулал олгосон.

2020 оны жилийн төсөв, 2021 оны жилийн төсвийн төсөл, төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээллийг www.sport.ub.gov.mn сайтад байршуулж нээлттэй мэдээлэн ажилласан.

Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Нийслэлийн төлөвлөгөөг www.sport.ub.gov.mn сайтад байршуулсан.

Байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, орон тооны талаарх мэдээллийг www.sport.ub.gov.mn сайтад байршуулсан.

Иргэд хүлээн авах хуваарийн дагуу 5 иргэнийг хүлээн авч уулзсан. Мэдээ тайланг улирал бүр гарган Нийслэлийн Нэгдсэн үйлчилгээний төв болон Нийслэлийн засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлж ажилласан.

“Удирдлагын академи”-ийн мэргэшүүлэх сертификаттай онлайн сургалтад хэлтсийн дарга-2, мэргэжилтэн-2 Төрийн албаны зөвлөлийн төлөвлөгөөт сургалтад дарга-1, мэргэжилтэн-1, Нийлэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан 4 удаагийн сургалтад дарга- 3, мэргэжилтэн-4 нийтдээ 12 удаагийн сургалтад давхардсан тоогоор 13 албан хаагчийг хамруулсан байна.

Түүнчлэн салбарын хэмжээнд зохион байгуулсан “Хууль эрх зүй”, “Цахим мэдээллийн системийн хэрэглээ” сэдэвт 2 удаагийн онлайн сургалтад нийслэл дүүргийн спортын хороодын давхардсан тоогоор 60 гаруй албан хаагчийг хамрууллаа.

в/ архив, албан хэрэг хөтлөлт, албан бичиг хэрэгжилт-97.9%

2019 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу мэргэжилтэн тус бүрээс архивын баримт хүлээн авах хуваарь гаргаж хуваарийн дагуу 2020 оны 02 дугаар сард байгууллагын архивт баримтыг хүлээн авч байнга хадгалах 65, 70 жил хадгалах 1, түр хадгалах 77, нийт 135 ш хадгаламжийн нэгжийг данс бүртгэлжүүлсэн.

Түүнчлэн Нийслэлийн архивт хүлээлгэн өгөх тусгай төрлийн баримтын бүртгэлийг archive.edoc.mn програмд дүрс бичлэгийн 29, кино 1, дуу авианы 6, гэрэл, фото зургийн 4 баримтын бүртгэлийг тус тус шивж оруулсан.

Байгууллагын 2020 онд хөтлөгдөх “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ыг боловсруулан байгууллагын даргаар батлуулж, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын edoc цахим системд 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдөр хөрвүүлсэн.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын edoc цахим системийн archive edoc-д байгууллагын даргын 2019 оны А, Б тушаал буюу байнга хадгалах захирамжлалын баримтыг цахим хувьд шилжүүлэн нягтлан шалгах ажиллагааг зохион байгууллаа.

<https://edoc.ulaanbaatar.mn/#/> программд ирсэн бичиг шийдвэрлэлтийн мэдээ:

Албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн edoc.ulaanbaatar.mn программыг бүрэн ашиглаж, 2020 онд манай байгууллагад нийт 370 албан бичиг ирснээс хариутай 100 бичиг ирж, 96-ийг хугацаанд нь шийдвэрлэж шийдвэрлэлт 98 хувьтай байна.

Байгууллагаас явуулсан бичиг 172 хяналт 100%.

Нийт ирсэн бичиг - 370

Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр бүртгэгдэн ирсэн бичгийн тоо – 3

Байгууллагаар бүртгэгдсэн бичгийн тоо – 16

Системээр бүртгэгдэн ирсэн бичгийн тоо – 351

Хуваарилагдаагүй бичгийн тоо – 0

Хариутай бичгийн тоо – 100

Хугацаандаа шийдвэрлэсэн бичгийн тоо – 96

Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн тоо – 4

Хугацаа хэтэрч шийдвэрлээгүй тоо – 0

Судалж байгаа бичгийн тоо – 0

Хугацаа дөхсөн бичгийн тоо – 0

Хугацаа сунгуулсан бичгийн тоо – 0

Хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь – 98%

Хариугүй бичгийн шийдвэрлэлтийн хувь – 99.42%

Хугацаандаа хаасан бичгийн тоо – 260

Зөрчил тооцогдсон албан бичгийн тоо – 0

Нийт ирсэн бичгийн шийдвэрлэлтийн хувь – 98.28%

Шийдвэрлэлтийн дундаж хувь 8.25 хувьтай.

Явуулсан албан тоот 175, 175 байгууллага, аж, ахуйн нэгжид илгээсэн байна.

г/ иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл

1. Манай байгууллагад 2020 оны 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 30-ны байдлаар байгууллага, иргэдээс 1 санал, 2 гомдол, 9 хүсэлт нийт 12 ирсэн нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 1 гомдол, 4 хүсэлтээр их байна.

Үзүүлэлт	2019.01.01 – 12.25		2020.01.01 – 12.25	
	Ирсэн тоо	Хувь	Ирсэн тоо	Хувь
Ирсэн хүсэлтийн тоо	7	100%	12	100%

2. Тус байгууллагад 2020 оны 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 30-ны хооронд байгууллага, иргэдээс 1 санал, 2 гомдол, 9 хүсэлт нийт 12 ирснийг өдөрт нь хүлээн авч шийдвэрлэн ажилласан. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа өмнөх оноос 3 хоног 06 цаг 18 минут болж багассан.

Байгууллагын вэб хуудас хөтлөх

“Байгууллагын эрхэм зорилго”, “үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл”, “байгууллагын зохион байгуулалтын бүтэц”-ийг байгууллагын sport.ub.gov.mn/ цахим хуудасны “Бидний тухай” цэсэнд болон мэдээллийн самбарт байршуулсан.

Тус хорооноос зохион байгуулсан нийтийн биеийн тамирын болон спортын 19 уралдаан тэмцээн, сургалт, арга хэмжээнүүдийн батлагдсан удирдамж, заавар, холбогдох мэдээ мэдээллийг байгууллагын www.sport.ub.gov.mn, www.ulaanbaatar.mn, www.news.mn цахим хуудас болон [www.facebook.com/Биеийн тамирын хамтлаг](http://www.facebook.com/Биеийн_тамирын_хамтлаг), “Маргааш болох үйл явдал”, “Хэвлэлийн төлөөлөгч”, “Нийслэлийн Спортын хороо” пэйж хуудас зэрэгт байршуулсан.

Байгууллагын өмч, санхүүгийн талаар:

Улсын төсвөөр 2020 онд 490.001.900 төгрөг батлагдсан. **Үүнээс:**

- ✚ Биеийн тамир, спортын арга хэмжээнд спортын зардалд 65,422,013 төгрөг
- ✚ Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулалд 190,556,314 төгрөг
- ✚ Ажил олгогчоос нийгмийн даатгалын даатгалд төлөх шимтгэл 24,578,063 төгрөг
- ✚ Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 5,020,000 төгрөг
- ✚ Хангамж, бараа материалын зардал 8,335,600 төгрөг
- ✚ Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг 2.000.000 төгрөг зарцуулсан байна.

Байгууллагын мэдээллийн самбарт байршуулах, шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу шилэн дансны “shilendans.gov.mn” цахим хуудсанд байгууллагын 2020 оны жилийн төсөв, 2019 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, 2020 оны төсвийн гүйцэтгэлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12-р сарын мэдээ, цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээ зэрэг 20 төрлийн 145 мэдээ, мэдээлэл, тайланг цахимд, 8 төрлийн мэдээллийг самбарт байршуулсан.

Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, ашиг орлогын, албан татварын тооцоо тайланг цаг хугацаанд нь гаргаж өр төлбөргүй ажилласан байна.

Үргүй зардлыг багасгах, төсвийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтанд тавих хяналтыг өндөржүүлж, төсвийн сахилгыг мөрдлөгө болгон ажилласан.

Биеийн тамир, спортын гадаад харилцаа, хамтын ажиллагаа – хэрэгжилт

Байгууллагын 2020 онд биеийн тамир, спортын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор ОХУ-ын “КЭС-БАСКЕТ” ТББ-тай хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр байгуулах, ОХУ-д болдог ЕБС-ийн сурагчдын сагсан бөмбөгийн лигийн финалын тоглолтод баг тамирчдаа оролцуулах, “Улаанбаатар марафон-2020” олон улсын гүйлт зохион байгуулах, Японоос илгээсэн жүдо бөхийн багшаар сургалт явуулах төслийг Улаанбаатар хотноо хэрэгжүүлэх зэрэг 10 гаруй арга хэмжээг гадаад, дотоодод зохион байгуулахаар төлөвлөсөн.

Энэхүү ажлын хүрээнд ОХУ-ын “КЭС-БАСКЕТ” байгууллагатай 60 удаа, Япон болон БНСУ-ын Жүдо бөхийн холбооны холбогдох ажилтантай 30 удаа цахим шуудангаар харилцсан.

Дэлхий дахины хэмжээнд тархаад Covid-19” цар тахал буюу коронавирусаас урьдчилан сэргийлэх Улсын онцгой комиссын 2020 оны 12 дугаар тогтоол, Нийслэлийн

Засаг даргын 2020 оны 2020 оны А/108, А/1241 дүгээр захирамжаар хурал цуглаан, спортын үйл ажиллагааг хориглосон тул зохион байгуулагдаагүй.

“Азийн хүүхдүүд-2020” олон улсын спортын наадмыг “Олон Улсын залуучуудын ногоон наадам” нэрээр зохион байгуулахаар болсон боловч Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108 дугаар захирамжаар олон нийтийг хамарсан спортын уралдаан тэмцээн, арга хэмжээ зохион байгуулахыг тодорхойгүй хугацаагаар хориглосон тул 2021 онд зохион байгуулахаар хойшлуулсан.

Судалгаа шинжилгээ, цахим сан, мэдээлэл /мэдээллийн технологи/, сурталчилгааны ажлын хүрээнд:

1. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа, цаг үеийн шаардлагатай мэдээ, мэдээллийг холбогдох гадаад, дотоодын хувь хүн, байгууллагатай цахим шуудангаар 2020 оны жилийн эцсийн байдлаар 5000 гаруй удаа мэдээ, мэдээлэл солилцсон.

2. Биеийн тамир, спортын чиглэлээр манай байгууллагаас зохион байгуулж байгаа үйл ажиллагааны талаар санал боловсруулж дүүргүүдийн Биеийн тамир, спортын хороодын хамт хэрэглэгчдээс санал асуулга авах ажлыг цаасан болон цахим хэлбэрээр зохион байгуулж 7000 хүнээс авч нэгтгэн боловсруулалт хийж байна.

3. Биеийн тамир, спортын төрийн байгууллагын үйл ажиллагааны 2019 оны мэдээг Үндэсний Статистикийн газрын маягтын дагуу 2020 оны 02 дугаар сарын 05-ны дотор хугацаанд нь нэгтгэн гаргаж Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газар, Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлж ажилласан.

Мөн дүүргийн Биеийн тамир, спортын хороодтой хамтран тус мэдээний үзүүлэлтүүдийг Биеийн тамир Спортын газрын Захиргааны статистик мэдээ, тайлан боловсруулах онлайн программд дүүрэг тус бүрээр бүрэн орууллаа.

Статистикийн мэдээ тайланд биеийн тамир, спортын байгууллага, барилга байгууламж, орон тоо, биеийн тамир, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээний тоо, багш, дасгалжуулагч, арга зүйч, тамирчдын тоо зэргийн мэдээлэл багтсан.

4. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтсээс эрхлэн гаргасан “Нийслэлийн мэдээ” пэйж хуудсанд байршуулсан “Ковид-19” цар тахлаас сэргийлэх, хамгаалах, дархлаа дэмжихтэй холбоотой мэдээ мэдээллийг манай байгууллагын хамт олон 2020 оны 11 дүгээр сарын 18-наас хойш нийт 2000 мэдээнд 2010 удаа LIKE дарж, 1500 удаа SHARE хийж, 40 удаа эерэг COMMENT бичиж, олон нийтэд хүргэсэн.

5. Мөн “Ковид-19-ийн эсрэг Идэвхтэй хөдөлгөөнд – Иргэн бүрт” уриан дор нэгдэцгээе” аяныг 2020 оны 11 дүгээр сарын 18-наас эхлэн 9 дүүргийн Биеийн тамир, спортын хороодтой хамтран зохион байгуулж, бүх насныхны дархлааг дэмжих 34-н дасгал хөдөлгөөн, дүүргүүдийн Засаг дарга нарын дэргэдэх өсвөрийн шигшээ багуудын тамирчдад зориулсан 400 орчим онлайн хичээлүүдийг “Нийслэлийн спортын хороо” пэйж хуудас болон 9 дүүргийн фэйсбүүк хуудсаар олон нийтэд хүргэсэн.



6. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн программ /erp.ulaanbaatar.mn/-ын хүний нөөцийн хэсэгт байгууллагынхаа ажилтан, албан хаагчдын мэдээ мэдээлэл, цалингийн мэдээллийг оруулах; үйл явдал, онцлог үйл явдлын хэсэгт орсон мэдээ мэдээллийг байгууллагын удирдлага, мэргэжилтнүүдэд танилцуулах; цаг үеийн шаардлагатай мэдээ мэдээллийг байршуулах; нийслэлийн удирдлагуудаас өгсөн үүрэг даалгавартай танилцах; цаг бүртгэлийн мэдээлэл хүсэлтийг тухай бүр оруулах; edoc.ulaanbaatar.mn; холбогдох хэлтэс, албадын мэргэжилтнүүдтэй холбогдож мэдээллээ харилцан солилцох, холбогдох утасны дугаар зэргийг авах зэрэг өдөр тутмын үйл ажиллагаандаа бүрэн ашиглаж байна.

7. Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх чиглэлээр байгууллагын дүрэм, дотоод журамд тусган хэрэгжилтийг хангаж цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор “СҮҮХҮНГИЙ” ХХК-тай 2019 оны 04 дүгээр сарын 01-нээс гэрээ байгуулан цагийн бүртгэлийн төхөөрөмжийг суурилуулан Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын системээр цагийн бүртгэлийг хянаж байна. Түүнчлэн Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 34 дүгээр хурлын тэмдэглэл, Нийслэлийн Онцгой комиссын 2020 оны 16 дугаар хурлын тэмдэглэл Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/1242 дугаар захирамжийн хүрээнд албан хаагчид гэрээсээ цахимаар ажиллаж <https://erp.ulaanbaatar.mn/> цахим системээр цаг бүртгүүлж байгууллагын үйл ажиллагааг цалгардуулахгүйгээр ажилласан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2020 онд ирсэн гэнэтийн болон төлөвлөгөөт 7 удаагийн хяналт шалгалтад хангалттай сайн гэсэн үнэлгээтэй үнэлэгдсэн.

8. Нийслэлийн Спортын хорооноос зохион байгуулсан биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн нийт 19 арга хэмжээг МҮОНТ, TV-5, MNC TV, ulaanbaatar.mn, news.mn, shuud.mn, sport.ub.gov.mn зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр нийт 20 гаруй удаа, [www.facebook.com/Биеийн тамирын хамтлаг](http://www.facebook.com/Биеийн_тамирын_хамтлаг), “Маргааш болох үйл явдал”, “Хэвлэлийн төлөөлөгч”, “Нийслэлийн Спортын хороо” пэйж хуудас зэрэгт сурталчиллаа.

9. Цахим хуудасны хууль, эрх зүйн буланд 2020 онд шинээр гаргасан эрх зүйн баримт бичгүүд болох “Биеийн тамир, спортын тухай” хууль, Засгийн газрын 2019 оны 335-р, 2020

оны 30, 103-р тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/108, А/1114, А/1241-р захирамжуудыг нэмж оруулсан. Байгууллагын нэр, бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотойгоор www.sport.ub.gov.mn цахим хуудсанд өмнө байршуулсан байгууллагын танилцуулга, дүрэм, дотоод журам зэргийг шинэчилсэн.

Байгууллагаас 2020 онд зохион байгуулсан биеийн тамир, спортын 19 арга хэмжээний мэдээ мэдээллийг оруулсан.

10. Анти вирусны програм суулгуулахаар “Програм хангамж худалдах, худалдан авах” гурвалсан гэрээ байгуулан 12 суурин компьютер, 2 зөөврийн компьютерт вирусны програм суулгуулсан.

11. Мэдээллийн технологийн өдөр тутмын хэвийн, аюулгүй ажиллагааг хангахын тулд байгууллагын албан хэрэгцээнд ашигладаг 4 компьютерыг Нийслэлийн Мэдээллийн технологийн газарт дуудлага өгч засвар хийлгэсэн.

12. Байгууллагын өдөр тутмын баримт бичиг боловсруулах үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор HP LaserJet M1132 маркийн 3 үйлдэлтэй принтер болон HP LaserJet 1102 маркийн 1 үйлдэлтэй принтерийн 285А маркийн хорыг 2020 онд 20 удаа захиалан авч албан хэрэгцээнд ашигласан.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. “БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ” ХЭРЭГЖИЛТ-100%

Г	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулан тухай бүр шинэчлэх.	“Байгууллагын эрхэм зорилго”, “үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл”, “байгууллагын зохион байгуулалтын бүтэц”-ийг байгууллагын sport.ub.gov.mn/ цахим хуудасны “Бидний тухай” цэсэнд болон мэдээллийн самбарт байршуулсан. Тус хорооноос зохион байгуулсан нийтийн биеийн тамирын болон спортын 19 уралдаан тэмцээн, сургалт, арга хэмжээнүүдийн батлагдсан удирдамж, заавар, холбогдох мэдээ мэдээллийг байгууллагын www.sport.ub.gov.mn , www.ulaanbaatar.mn , www.news.mn цахим хуудас болон www.facebook.com/ Биеийн тамирын хамтлаг, “Маргааш болох үйл явдал”, “Хэвлэлийн төлөөлөгч”, “Нийслэлийн Спортын хороо” пэйж хуудас зэрэгт байршуулсан.	100%
Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал;			
1.	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулсан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/230, А/241 дүгээр захирамжаар бүтэц орон тоо шинэчлэн батлагдсантай холбогдуулан албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 104 дүгээр тогтоолоор батлуулж Төрийн албаны Зөвлөлийн Нийслэл дэх Салбар зөвлөлд 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдөр сул орон тооны захиалгыг хүргүүлэн 5 сул орон тоог ил тод нээлттэй зарласан.	100%
2.	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулсан тухай бүр шинэчлэх;	Байгууллагын даргаар батлуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн дотоод дүрэм”-ийг http://sport.ub.gov.mn/?page_id=130 байгууллагын цахим хуудсанд байршуулсан.	
3.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулсан тухай бүр шинэчлэх;	Байгууллагын хүний нөөцийн жилийн төлөвлөгөө, хагас, жилийн тайлан мэдээний хэрэгжилтийг хагас жилээр шинэчлэн байршуулж ажилласан.	100%
4.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулсан мэдээлж байх;	Байгууллагын хүний нөөцийн жилийн төлөвлөгөө, хагас, жилийн тайлан мэдээг байгууллагын самбарт болон цахим хуудсанд байршуулан иргэдэд сурталчилан ажиллаж байна.	100%
5.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулсан мэдээлж байх;	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн биелэлтийг үнэлж дүгнэх журам”-ыг байгууллагын цахим хуудас /http://sport.ub.gov.mn/?page_id=122/ -нд байршуулж, олон нийтэд мэдээлж байна.	
Хэсгийн дундаж хувь:			100%
Хэрэгжилтийн дундаж хувь:			100%


ШИЛЭН ДАНС

<p>Шилэн дансны мэдээлэл оруулах</p>	<p>Монгол Улсын Шилэн дансны тухай хууль тогтоомжид заасан хуваарийн дагуу 2020 онд оруулбал зохих мэдээллүүдийг цаг хугацаанд нь оруулсан. Үүнд:</p> <p>1. “Бүтэн жилээр оруулах мэдээлэл”-ээс:</p> <ul style="list-style-type: none"> - 01-р сарын 10-ны дотор оруулах шаардлагатай “Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл”, “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө” бүлгүүдийн “ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТЕНДЕР, ХУДАЛДАН АВАЛТ” төрөлд “ОРУУЛАХ МЭДЭЭЛЭЛ БАЙХГҮЙ” гэсэн мэдээлэл оруулсан. - 01-р сарын 16-ны дотор оруулах шаардлагатай “Байгууллагын батлагдсан төсөв” бүлгийн “ТӨСӨВ/ГҮЙЦЭТГЭЛ” төрөлд 490.001.000 төгрөгийн төсвийн мэдээлэл оруулсан. <p>2. “Улирал бүр оруулах мэдээлэл”-ээс:</p> <ul style="list-style-type: none"> - “Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт” бүлгийн “ТӨСӨВ/ГҮЙЦЭТГЭЛ” төрөлд 1-р улирлын мэдээг заасан хуваарийн дагуу 4-р сарын 08-ны дотор тус тус оруулсан. <p>3. “Сар бүр оруулах мэдээлэл”-ээс:</p> <ul style="list-style-type: none"> - “Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл” бүлгийн “ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТЕНДЕР, ХУДАЛДАН АВАЛТ” төрөлд, “Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт” бүлгийн “БУСАД” төрөлд 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12 дугаар саруудын “ОРУУЛАХ МЭДЭЭЛЭЛ БАЙХГҮЙ” гэсэн мэдээг заасан хуваарийн дагуу дараа сарын 08-ны дотор оруулсан. - “Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт” бүлгийн “ТӨСӨВ/ГҮЙЦЭТГЭЛ” төрөлд 1, 2, 3, 4, 5, 6, 9, 10, 11, 12 дугаар саруудын мэдээг заасан хуваарийн дагуу дараа сарын 08-ны дотор оруулсан. <p>4. “Тухай бүрт нь оруулах мэдээлэл”-ээс:</p> <ul style="list-style-type: none"> - “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл”, “Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт” болон “Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн” бүлгийн “БУСАД” төрөлд 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12 дугаар саруудад “ОРУУЛАХ МЭДЭЭЛЭЛ БАЙХГҮЙ” гэсэн мэдээллийг тухай бүр оруулсан. <ul style="list-style-type: none"> - “Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт” бүлгийн “ТӨСӨВ / ГҮЙЦЭТГЭЛ” төрөлд 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12 дугаар саруудын мэдээнд “Өөрчлөлт байхгүй” тухай мэдээллийг заасан хуваарийн дагуу дараа сарын 08-ны дотор оруулсан. - “Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл” бүлгийн “Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт” төрөлд 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12 дугаар саруудад “БАЙХГҮЙ” гэсэн мэдээлэл оруулсан. - “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” бүлгийн “БУСАД” төрөлд 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12 дугаар саруудад холбогдох мэдээллийг оруулсан. - “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ” бүлгийн “ТӨСӨВ/ГҮЙЦЭТГЭЛ” төрөлд 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12 дугаар саруудын орлого, зарлагын мэдээллүүдийг тус тус оруулсан. - “Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг” бүлгийн “ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТЕНДЕР, ХУДАЛДАН АВАЛТ” төрөлд “Байхгүй” гэсэн мэдээлэл оруулсан 	<p style="text-align: center;">100%</p>
<p>Үнэлгээний дундаж хувь 100%</p>		

ТАВДУГААР БҮЛЭГ. “БУСАД МЭДЛЭЭЛЭЛ”

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 10

дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар, “Хилийн зарим боомтыг түр хаах, нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах тухай” 39 дүгээр, “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар, “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 63 дугаар тогтоолууд, Улсын онцгой комиссын 2020 оны тогтоол, “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108 дугаар, “Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/166 дугаар, “Уриалга гаргах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай” А/168 дугаар, “Өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/191 дүгээр захирамжууд Нийслэлийн Онцгой комиссын даргын 01, 02 дугаар тушаал, Нийслэлийн онцгой комиссын 2, 3, 4 дүгээр хурлын шийдвэр, Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал Онцгой комиссын орлогч даргын 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдөр баталсан “Шинэ төрлийн коронавирус /Covid-19/-ийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ” авч иргэдэд зөвлөмж мэдээлэл өгч эргүүлээр ажиллах хуваарийн дагуу Нийслэлийн Спортын хорооны 10 албан хаагчид 2020 оны 02 дугаар сарын 20-ноос 2020 оны 06 дугаар сарын 04-ний хооронд нийт 106 удаагийн эргүүл хийж давхардсан тоогоор 8495 хүнд 1755 аж ахуйн нэгж, байгууллагын ариутгал халдваргүйтгэлтэй танилцаж, заавар зөвлөгөө өгч, 845 хүн амны хаалт зүүгээгүй байхад нь анхааруулж ажилласан.



шийдвэрүүд, Нийслэлийн Засаг даргын 2020 оны



хариуцсан нэгдүгээр орлогч бөгөөд Нийслэлийн



2020 оны 02 дугаар сарын 20-ноос 03 дугаар сарын 02-ны хооронд эргүүл хийсэн байдал:

Нийслэлийн Спортын хорооноос 2020 оны 02 дугаар сарын 20-ноос 03 дугаар сарын 02-ны өдрүүдэд иргэд, хуулийн этгээдэд коронавирусийн халдвараас сэргийлэх талаар зөвлөмж, зөвлөгөө өгч, эргүүлээр ажиллах албан хаагчдын хуваарийг Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2020 оны 2/34 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Тус байгууллага нь Нийслэлийн Эрүүл мэндийн газарт 200.000 /хоёр зуун мянга/ төгрөг шилжүүлэн шинэ коронавирусийн халдвараас сэргийлэх 10.000 ширхэг зөвлөмж хуудсыг авч, “Нийслэлийн онцгой комисс – Эрүүл” гэсэн таних тэмдэгийг батлагдсан загварын дагуу хийлгэн, Баянгол дүүргийн Онцгой комиссын “Шинэ төрлийн коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх тухай” 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 02 дугаар тушаалын хүрээнд батлагдсан хуваарийн дагуу Баянгол дүүргийн 23 дугаар болон 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 12 удаа эргүүлээр гарч, иргэд, хуулийн этгээдэд коронавирусийн халдвараас сэргийлэх талаарх 10000 ширхэг зөвлөмж тарааж, давхардсан тоогоор 168 ААНБ-ын ариутгал, цэвэрлэгээнд хяналт тавьж, 2710 хүнд зөвлөгөө өгч, амны хаалтгүй явсан 62 хүнд шаардлага тавьж, зөвлөгөө өгч ажилласан.



2020 оны 03 дугаар сарын 03-наас 03 дугаар сарын 30-ны хооронд эргүүл хийсэн байдал:

Нийслэлийн Спортын хорооны 10 албан хаагчид батлагдсан хуваарийн дагуу Баянгол дүүргийн 8-р бүс буюу 23, 11 дүгээр хороодын хуваарилагдсан газруудаар 2020 оны 03 дугаар сарын 03-30-ны өдрүүдэд нийт 29 эргүүл хийж, давхардсан тоогоор 4147 хүнд зөвлөмж танилцуулж, давхардсан тоогоор 726 аж ахуйн нэгж байгууллагуудын ариутгал халдваргүйтэл, цэвэрлэгээг шалган, амны хаалтгүй явсан 131 хүнд шаардлага тавьж, зөвлөгөө өгч ажилласан.



2020 оны 04 дүгээр сарын 01-нээс 04 дүгээр сарын 30-ны хооронд эргүүл хийсэн байдал:

Улсын Онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/268, А/483 дугаар захирамжаар нутгийн захиргааны байгууллагуудын 12 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийг /ганц бие эцэг/ 04 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд хорогдуулсан цагаар ажиллуулах шийдвэрийг гаргаж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг байгууллагын удирдлагуудад үүрэг болгосон. Үүний дагуу Нийслэлийн Спортын хорооноос 4 албан хаагч Баянгол дүүргийн 8-р бүс буюу 23 дугаар хороодын хуваарилагдсан газруудаар батлагдсан хуваарийн дагуу 2020 оны 04 дүгээр сарын 01-30-ны өдрүүдэд 30 удаагийн эргүүл хийж, давхардсан тоогоор 824 хүнд зөвлөмж танилцуулж, давхардсан тоогоор 412 аж ахуйн нэгж байгууллагуудын ариутгал халдваргүйтэл, цэвэрлэгээг шалган, амны хаалтгүй явсан 362 хүнд шаардлага тавьж, зөвлөгөө өгч ажилласан.



2020 оны 05 дугаар сарын 01-нээс 05 дугаар сарын 31-ний хооронд эргүүл хийсэн байдал:

Баянгол дүүргийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын даргын 2020 оны 04 дүгээр сарын 29-ний 43 тоот албан бичгээр ирүүлсэн хуваарийн дагуу Нийслэлийн Спортын хорооны ажилтнууд Баянгол дүүргийн 8-р бүс буюу 23 дугаар хороодын хуваарилагдсан газруудаар 2020 оны 05 дугаар сарын 01-31-ний өдрүүдэд 31 удаагийн эргүүл хийж, давхардсан тоогоор 735 хүнд зөвлөмж танилцуулж, давхардсан тоогоор 402 аж ахуйн нэгж байгууллагуудын ариутгал халдваргүйтэл, цэвэрлэгээг шалган, амны хаалтгүй явсан 269 хүнд шаардлага тавьж, зөвлөгөө өгч ажилласан.



2020 оны 06 дугаар сарын 01-нээс 06 дугаар сарын 04-ний хооронд эргүүл хийсэн байдал:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 03/2448 тоот албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу Нийслэлийн Спортын хорооноос 2020 оны 06 дугаар сарын 01-04-ний өдрүүдэд Баянгол дүүргийн 8-р бүс буюу 23 дугаар хороодын хуваарилагдсан газруудаар 4 удаагийн эргүүл хийж, давхардсан тоогоор 79 хүнд зөвлөмж танилцуулж, давхардсан тоогоор 47 аж ахуйн нэгж байгууллагуудын ариутгал



халдваргүйтэл, цэвэрлэгээг шалган, амны хаалтгүй явсан 21 хүнд шаардлага тавьж, зөвлөгөө өгч ажилласан.

Мөн байгууллагын даргын 2020 оны 02 дугаар сарын 18-ний өдрийн А/07 дугаар тушаалаар албан хаагчдыг дархлааг дэмжих, өрөө тасалгаанд ариутгал, халдваргүйжүүлэх зорилгоор 273,500 төгрөгийн хэрэглэл материал, дархлаа дэмжих витамин зэргээр ханган ажиллаа.

2. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1016, А/1118 дугаар захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн Ажлын албаны даргын 2019 оны “Сайжруулсан шахмал түлш болон түүхий нүүрсний хэрэглээ түүний зохион байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих албан тушаалтны хуваарь”, нийслэл, дүүргийн Онцгой комиссын хурлын тэмдэглэлүүд, “Нийслэл дүүргүүдийн Онцгой комиссын шуурхай штабын үйл ажиллагаанд 24 цагаар хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангах ажлын удирдамж”-ын хэрэгжилтийг ханган ажиллаа.

Батлагдсан хуваарийн дагуу “Таван толгой түлш” ХХК-ийн “MNS 5679:2019 стандартын сайжруулсан түлшийг Сонгинохайрхан дүүргийн 27 дугаар хорооны айл, өрх, хэрэглэгчдэд түгээх, хангах, түүхий нүүрс түлэх асуудал дээр хяналт тавих ажлыг Сонгинохайрхан дүүргийн Хөдөө аж ахуйн хэлтэстэй хамтран хийж өдөр бүр дүүргийн Онцгой штабд мэдээ өгч ажилласан.



Сонгинохайрхан дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, “Таван толгой түлш” ХХК-ийн ажилтан, албан хаагч нар болон тус хорооны мэргэжилтэн албан хаагч нартай хамтран 130 айл, өрх, аж ахуй нэгжүүдээр орж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж заавар, зөвлөмж холбогдох материалуудыг хүргэх, сайжруулсан түлшний хяналтын “Сайн карт”-ыг хүргэх, пийшин, зуухыг хөнгөн болон хүнд хэлбэрээр янзалж ашиглалтыг сайжруулах, угаарын хий мэдрэгч төхөөрөмжийн ажиллагааг шалгаж танилцуулан угсарч суурилуулах ажлуудыг хамтран гүйцэтгэж ажиллалаа.

Мөн “Нийслэл дүүргүүдийн Онцгой комиссын шуурхай штабын үйл ажиллагаанд 24 цагаар хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангах ажлын удирдамж”-ийн дагуу 24 цагаар хариуцлагатай зохицуулагчийн үүргийг 2020 оны 02 дугаар сарын 12-13-ны өдөр хийж гүйцэтгэлээ.



Түүнчлэн байгууллагын даргын 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/06 дугаар тушаалаар Онцгой комиссын зохицуулагчаар ажиллахад албан хаагчдын дархлааг дэмжих хоол, унаа, утасны зардалд зориулж 1.020.000 төгрөгийн зарцуулсан.

2020 оны жилийн эцсийн үйл ажиллагааг явуулахад гарсан хүндрэл бэрхшээл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/241 дүгээр захирамжаар манай байгууллагын бүтэц орон тооны хязгаарыг 16 албан хаагчтай байхаар баталсан.

Одоогоор 11 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

Төрийн албаны нөөцөд ажлын байрны шалгуурыг хангасан иргэн байхгүй учраас сул орон тоог нөхөн боломжгүй байгаа тул ажлын ачаалал их байна.

Дэлхий нийтэд тархаад байгаа “Covid-19” цар тахал буюу коронавирусын улмаас жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг томоохон спортын арга хэмжээнүүд тасалдаж, иргэдийн спортоор хичээллэх орчин нөхцөл, заал танхим нээгдээгүй нь улмаас нийслэлийн иргэд хөдөлгөөны дутагдалд орж эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх асуудал тулгараад байна.

Нийслэл, Найлайх, Баянзүрхийн Спорт цогцолборын барилгын ажлын төсвийг 2020 оны улсын төсөвт тусгаагүй тул барилгын ажлын явц бүрэн зогссон.

Тус спортын цогцолборын барилгын ажлыг гүйцэтгэх төсвийг 2021 оны төсвийн тодотгол буюу 2022 оны төсвийн төсөлд суулгаж барилгын ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН СПОРТЫН ХОРООНЫ
ДАРГА

Ж.ГАНБОЛД

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ГАДААД ХАРИЛЦАА, СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ,
ТАЙЛАН МЭДЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Н.ӨЛЗИЙЖАРГАЛ